



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 04 өдөр

Дугаар 8166

Арвайхээр сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.4, 32.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд өвөлжилт, хаваржилт хүндэрсэнтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комисс болон Олон Улсын байгууллага, иргэн, аж ахуйн нэгжүүдээс аймгийн хэмжээнд шилэн болон цагаан зудтай, цагаанаар зудархуу сумдын малчид, аймгийн Онцгой комисс холбогдох байгууллагад өвс, тэжээл, хүнс, эд материалын тусlamж үзүүлсээр байгаа тул хандив тусlamжийг орон нутагт хүлээн авч, хаваржилт хүндэрсэн айл өрхүүдэд хуваарилах, олон нийтэд ил тод мэдээлэх, сурталчлах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

2. Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комисс болон Олон Улсын байгууллага, иргэн, аж ахуйн нэгжүүдээс ирсэн хандивыг бүртгэл хөтлөн хүлээн авах, хувиарлах, тусlamж хандивыг хүлээн авсан малчид, албан тушаалтнаар гарын үсэг зуруулж баталгаажуулах, нэгдсэн тайланг аймгийн Засаг даргын зөвлөлд хэлэлцүүлэн, иргэдэд нээлттэй сурталчлах ажлыг зохион байгуулахыг ажлын хэсэг (О.Сумъяасүрэн)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



И.ДОРЖСҮРЭН

0224 11 0348

Аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар
сарын 16-ны өдрийн 16:00 дугаар
захирамжийн хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: О.Сумъяасүрэн (аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд: Ц.Идэрсайхан (аймгийн Засаг даргын Тамгын газрын
Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)

Д.Одонбаяр (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын
хүрээний агентлаг Онцгой байдлын газрын дарга, дэд
хурандаа)

С.Цэдэнбалжир (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын
хүрээний агентлаг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)

Д.Шивааннүрдэв (аймгийн Засаг даргын эрхлэх
асуудлын хүрээний агентлаг Эрүүл мэндийн газрын
дарга)

М.Дэлгэрсайхан (Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн
захирагч, хурандаа)

Ш.Мөнхцэцэг (аймгийн Засаг даргын Тамгын газрын
хэвлэл мэдээлэл хариуцсан ажилтан)

Нарийн бичгийн дарга: Т.Эрдэнэбаяр (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын
хүрээний агентлаг Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал
Үржлийн албаны Бэлчээр, тэжээл усан хангамж
хариуцсан мэргэжилтэн)

-оOo-